

21-Р ЗУУНЫ ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛ: ШИНЭ НЭГДМЭЛ БОДЛОГО, ЧИГ ХАНДЛАГА

Ц. Шаравцэрэн *

Дэлхий ертөнц өөрчлөгдөхийн хэрээр боловсролын чиг хандагууд ч өөрчлөгдөж байна. Орчин үеийн боловсролын, багшлах арга зүйд шинэ шинэ өөрчлөлтүүд ихээр гарч, хуучин аргууд онцлог шинэ нээлтүүдээр баяжиж байна. Эдгээр нээлтүүдийн нэгэн чухал зорилтот тал нь урьд өмнөөс уламжлагдан ирсэн хичээлийг бүх сурагчдад нэгэн хэлбэрээр заах арга барилаас татгалзаж багшлах арга барилын үндсэнд хувь хүний хувьд өөрийгөө нээн илрүүлэх, бусдад түгээх хангалттай мэдлэг эзэмшихэд өөрийгөө зориулах тийм шинэ үе ирж байгаад оршино. Боловсролын энэ өөрчлөлтөд томоохон алхам болж чадах салбар нь урлаг бөгөөд, ардын болон дэлхий нийтийн дуу хөгжмөөр дамжуулан боловсролд цогц нөлөө үзүүлэх боломжтой.

Хүн төрөлхтөний хөгжил нь төвөөс зугтах ба төвд тэмүүлэх хүчнүүдийн нэгэн нэгдэл хэмээн үзэж болно. Энэ хоёр хүчний нэг нь дутагдах нөхцөлд нөгөө нь үгүйлэгдэж эхлэх ба тэгш байдалд байснаар нэг нь нөгөөгөө нөхөж байх юм. Бидний эргэн тойронд байгаа бодит байдал нь шинжлэх ухааны шинэ шинэ мэдээллүүд, нээлтүүдийн дунд хөгжиж байгаа ба шинэ ололтуудад хязгаар үгүй мэт санагдах боллоо. Шинэ шинэ шинжлэх ухаан гарч ирэхийн зэрэгцээ үнэнийг эрэлхийлэгч нарын хувьд бүхий л шинэ мэдээллүүдийг цогц нэгдэлд оруулах, хоорондын хамтын уялдаа холбоог тодорхойлох хүнд үүргийг хүлээх болж байна. Гэвч цогцоор нь нэгдмэл байдалд оруулах чиг баримжаа нь сүүлийн үед дэлхий даяар хүчээ авч байгаа нь сайшаалтай. Үүний нэгэн тод илрэл нь хөгжмийг бусад хичээлүүдтэй холбох ба бүхий л аргуудын дотроос хамгийн өгөөжтэй, мөн хялбарт тооцогдож болох арга юм. Учир нь хөгжмийн урлагийн гол мөн чанар нь өөрөө цогц бөгөөд ямар ч хичээлд хөгжмийг ашиглаж дүрслэл, тайлбар хийх боломжтой. Энэ нь хөгжим бол хүний сэтгэлийг хөдөлгөх хамгийн хүчтэй хөдөлгүүр мөн гэдгийг тодорхойлохоос гадна хөгжмийн түүх нь өөрөө хүн төрөлхтөний түүхийг ямар ч үгсээс илүү тайлбарлах увьдастай байдагт оршино. Оросын нэрт хөгжмийн зохиолч Танеев “Хэрвээ манай гарагт харь гаригийнхан ирвэл Бетховены 5-р симфонийг сонсгоход л хангалттай” хэмээн хэлсэн байдаг нь хөгжмийн увьдасыг тодорхойлон хэлсэн үгс билээ. Эрт дээр үеэс хөгжин ирсэн хөгжмийн урлагийн түүх өнөөдөр зөвхөн хөгжмийн зэмсэгээр ая эгшгийг дуурьсуулах бус телевиз, компьютер, гар утас гэх мэт техникийн хэрэгслүүдээр

* Монгол Улсын Боловсролын Их Сургууль

дамжуулан тоглогдох болтлоо тархаж байгаа нь хөгжим гэдэг нь хичнээн цогц нөлөөг бидний амьдралд үзүүлж байгаагаагийн илрэл юм.

Хөгжмийг бусад хичээлүүдийн агуулга, туршлагатай холбон заах нь суралцагсдын хөгжмийн мэдлэгийг тэлэх, хөгжмийн төрөл жанрын онцлог, ялгааг таних, урлагийн бусад төрлийг ойлгохоос гадна бодит амьдралын мөн чанарыг болон дэлхий ертөнцийн оршин тогтнолын олон талыг ойлгоход ч ач нөлөөтэй юм.

Эрдэмтэд олон жилийн өмнөөс сэтгэл судлалын туршилтуудыг хөгжмөөр дамжуулан хийж ирлээ. Эдгээр туршилтууд нь эхний үед хөгжмийн хүчийг батлахад оршиж байсан бол одоо үед хөгжмөөр дамжуулан хийх туршилтууд нь хэрхэн үр нөлөөгөө үзүүлж байгааг батлахад орших болжээ. Тоо бодлого, унших гэх мэт суурь хичээлүүдийн явцад хөгжим нь хэрхэн нөлөөлж чадах, мөн бусад, хөгжмийн бус хичээлүүдийн амжилтад ч хөгжим хэрхэн нөлөөгөө үзүүлж байгааг судалж, эрдэмтэд сэтгэл судлалын тусгай загварыг хайж байна. Энэхүү загварын гол зорилго нь хөгжим хүнд нийгэм-соёлын утга санааг гүн суулгах хүчтэй ба даяарчлагдаж байгаа өнөөгийн дэлхийн иргэд бие биенээ ойлгож хамтран оршин тогтноход хөгжмийн нөлөөг батлан гаргахад оршиж байна. Бусад орны соёл, түүхийг ойлгон судлахад тухайн орны хөгжмөөр дамжуулан судлах нь хамгийн ихээр үр нөлөөгөө өгөж байгаа нь батлагдаж байгаа юм. Монголын морин хуур, Америкийн поп болон джаз, баруун европын сонгодог хөгжим нь тухайн улс орныхоо амьдрал, ёс заншил, түүхийг таниулах хамгийн гол хүч нь билээ.

Шинэ зуунд, хүний мэдлэг, мэдлэгийн чадвар болон ухаалаг чанарыг судлах аргачлал нь шинэ түвшинд хүрж байна. Гарвардын их сургуулийн сэтгэл судлаач Ховард Гарднер хүний ухаалаг чанарыг /интелект/ судлах шинэ онол боловсруулан дэвшүүлсэн нь сүүлийн жилүүдэд онцгой анхаарал татаж байна. Энэ онол нь хүн олон тооны ухаалаг чанартай гэдгийг батлах зорилготой ба одоогийн байдлаар, нэг хэмжигдэхүүнээр хэмжих 8 төрлийн ухаалаг чанар байгааг тодорхойлжээ. Өнөөг хүртэл хүн төрөлхтөн бид биеэ авч явах нэгэн зан үйлтэй мэт ойлгон ирсэн. Харин олон тооны ухаалаг чанаруудыг судалснаар хувь хүн бүрийн ухаалаг чанар нь давтагдашгүй бөгөөд үүнд үндэслэн боловсролын зохион байгуулалтыг өөрчлөх, хувь хүн рүү чиглүүлэх нь зүйтэй хэмээсэн шинэлэг үзэл бодол үүсч байгаа юм. Гарднерийн удирдсан эрдэмтдийн багийн дүгнэлтээр хүний үндсэн ухаалаг чанарууд нь: хэл ярианы, математик-логик, орон зайн, хөгжмийн, биеийн, хүн хоорондын, хувь хүн доторхи, байгалийн болон сэтгэл хөдлөлийн гэсэн тодорхойлолтуудад хуваагдаж байна. Эдгээр нь цаг зуурын тодорхойлолтууд бөгөөд олон ургалч үзэлд суурилсан, цаашид олон олон асуудлыг дэвшүүлэн тавих боломжтой юм. Өгөгдсөн ухаалаг чанараа хувь хүн олон салбарт ашиглах боломжтой билээ. Жишээ нь хөгжмийн урлагт зөвхөн хөгжмийн ухаалаг чанар хэрэгтэй болоод зогсохгүй хүн хоорондын, орон зайн, хувь хүн доторхи, математик-логикийн ухаалаг чанарууд ч ашиглагдах юм. Энэ нь ухаалаг чанар нь хүний биологийн болон сэтгэл санааны чадамжтай шууд холбоотой ба гадаад ертөнцөөс ирэх тодорхой элементүүдтэй дасан зохицох чадвартай байдагтай холбоотой юм. Жишээ нь хөгжмийн ая эгшиг, орон зайн мэдрэмж бүрийг хувь хүн өөрийн туршлага, соёлын хүчин зүйлүүд, ерөнхий сэдэл дээрээ тулгуурлан хүлээж авах чадвар боломж өөр өөр байдаг.

Дээр дурьдагдсан зүйлүүдийг ерөнхийлөн авч үзвэл, эдгээр нь боловсролын нэгдмэл цогц хандлага хэмээн тодорхойлогдож болох ба сургалтын үйл явцад үзэгдэх өөр өөр бие даасан салбаруудын хамтрал, гинжин хэлхээ болох юм. Мөн өөр нэгэн нэгдэлээр тодорхойлж болно. Энэ нь өргөн агуулга багтаасан хичээлийн хөтөлбөр юм. Хөгжмийн

боловсрол, хөгжмийн хичээл нь олон салаа мөчиртэй мод мэт дүрслэгдэж болох ба дэлхийн болон үндэсний хөгжмийн урлагийн түүх, хөгжмийн зохиолчдийн амьдрал уран бүтээл, түүхийн явц, тухайн нийгмийн өөрчлөлтүүдийг багтаахаас гадна хөгжмийн урлагийн төрөл, жанр мөн онолын суурь болон дэлгэрэнгүй мэдлэгийг багтаасан байдаг.

Өнгөрсөн зууны дунд үеэс гараагаа эхлүүлсэн Монголын мэргэжлийн хөгжмийн боловсрол нь Оросын болон европын сонгодог хөгжим, Монголын ардын хөгжим гэсэн хоёр чиглэлээр хичээлийн хөтөлбөр боловсруулагдан ирсэн ба энэ нь дэлхийн ихэнхи орнуудын хөгжмийн боловсролын явцтай ижил юм. Мөн үүний зэрэгцээ ерөнхий боловсролын сургуулиудын дуу хөгжмийн хичээлийн хөтөлбөр ч бас дээрхи хоёр чиглэлээр боловсруулагдсан байна. Хэдий тийм ч шүүмжлэлтэй талууд ерөнхий боловсролын дуу хөгжмийн хичээлийн агуулгад ихээр ажиглагдана. Энэ нь хөгжим хэмээх энэ урлагийн бүтэцийн талаар өгөх хамгийн энгийн ойлголтууд манайд үгүйлэгдэж байгаатай холбоотой мэт санагдаж байна. Хөгжмийн боловсролоор дамжуулан хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх дэлхийн орнуудын туршлагыг олноор харж уншиж болно. Үүний нэг жишээ нь Паневритмия буюу хөдөлгөөнт гимнастикийн дасгалуудын нэгдэл юм. Манай оронд эрт дээр үеэс хөгжиж ирсэн үндэсний тойрон бүжиг нь паневритмийн энэхүү дасгалтай олон талаараа ижил төстэй юм. Паневритмия нь 20 зууны эхэнд Болгар улсад үүссэн гэх ба байгалийн үзэсгэлэнт газарт хамтран хийх хөгжимт дасгал ба хөгжим, үг, дасгал нийлж нэгэн утга санааг илэрхийлэх ба 28 төрлийн хөгжмийн хэмнэл, хийл хөгжмийн аялгуут тоглолтыг ашигладаг байна. Хөгжмийн боловсролд паневритмийн ашиглах нь зүүн европын орнуудад сүүлийн жилүүдэд ихээхэн тархаж байна. Гол учир нь, нэгэн цэгт хөгжим, үгийн ба уран сайхны урлаг, бүжиг, сурган хүмүүжүүлэх аргачлал, сэтгэл судлалын сургалт, үндэсний хөгжим, бэлэгдэлийн урлаг, гоо зүй, гүн ухаан, биеийн хөгжил ба эрүүл мэнд, мөн байгаль хамгаалал зэрэг нь төвлөрсөн гэж үздэгт оршиж байгаа юм. Манай тойрон бүжиг ч бас паневритмийн урлагтай олон талаараа ижил төстэй ба үндэсний онцлог хөгжмийн хэмнэл, хөдөлгөөнөөрөө онцгойрох билээ. Монголын тойрон бүжигт дуулагдах дуу нь нарлаг өдрүүд, нарны туяа, уул ус, цэцэг навчисын тухайн өгүүлэх ба үүгээрээ бид хүүхдийг бага наснаас нь хүн байгалийн холбоог мэдрүүлэх, бие биенээ хүндэтгэх, хөгжмийн болон бүжгийн урлагаар дамжуулан сэтгэлийн таашаал эдлэх зэрэг хүмүүжлийн гол ач холбогдолтой амьдрах ухаанд сургах юм. Сүүлийн жилүүдэд язгуур урлагийн “Алтай” хамтлагийн хөгжимчид манай нэрт хөгжимчид Ч.Мөнх-Эрдэнэ, Д.Ганпүрэв нартай хамтран Улаанбаатар хотод тойрон бүжгийг түгээн дэлгэрүүлж байгаа ба тэдний бүтээн байгуулсан асар майхан нь хотын төвд зуны цагаар үйл ажиллагаагаа явуулж байна. Миний ажигласнаар, тойрон бүжигт хувь хүн өөрийн хөдөлгөөнийг хөгжмийн хэмнэлд тааруулан бүжиглэхээс гадна, багаар бүжих хэмнэлийг чухалчлах естой ба энэ нь нэг талаар хүүхдийг бага наснаас нь багаар ажиллах, нэг нь нөгөөгөөсөө хамааралтай явагдах амьдрах ухаанд сургаж байгаа мэт санагдана. Сүүлийн жилүүдэд багаар ажиллах чадвар, түүнийг хэрхэн хөгжүүлэх талаар их ярьж сурталчлах болжээ. Багаар ажиллах арга барил нь нийгмийн тогтолцооны оршин тогтнохын нэгэн хэлбэр нь юм. Хэрвээ урлагийн боловсролоор дамжуулан багаар ажиллах чадварыг хөгжүүлсе гэж үзвэл тойрон бүжиг нь хамгийн тохиромжтой аргачлалуудын нэг болох юм. Яагаад гэвэл бүжиглэгч нь хэдийгээр хувь хүн боловч бие биенээсээ хамааран хамтаар оролцох бүжиг тул багийн ажиллагааны сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой юм. Тойрон бүжигт оролцож буй хувь хүн бүрээс бүжгийн бүтэц

шалтгаалах ба үүнд тойргын хэлбэр, хөдөлгөөний синхрон, хөгжмийн хэмнэлд хэрхэн хамтаар тохируулан бүжих зэрэг нь орно. Сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны гол зорилго нь хувь хүний хүмүүжил төлөвшил билээ. Хөгжмөөр, урлагаар дамжуулан хүмүүжлийн ажил явуулах нь хувь сурагч зөвхөн өөрт байгаа авьяас чадварыг нээн илэрүүлэхээс гадна бусдыг ойлгох чадварт суралцах юм. Хичээлийн танхимд олноор нь суулган дуу зааж сургадаг хуучинсаг хэлбэрээс биеийн хөдөлгөөний ажиллагааг урлагтай холбосон нь суралцагсдыг хичээлд сонирхолтой болгох, өөрийнхөө үзэл санааг бусдад илэрхийлж сурах, илүү амьдралтай, эрх чөлөө, сэтгэлгээний өргөн боломжуудыг нээж олох чадваруудад сургах юм. Паневритм, тойрон бүжгүүдээс гадна сүүлийн жилүүдэд хөгжмөөр дамжуулан боловсрол олгох сонирхотой аргууд олноор төрөн гарч байна. Хөгжмөөс гадна монгол хэл, биеийн тамир, байгалийн шинжлэл, эрүүл амьдар ухаан зэрэг хичээлүүдийн үндсэн хэлбэрүүдийг тойрон бүжгээр дамжуулан сургах боломжтойгоос гадна дээр дурьдсан Ховард Гарднерын дэвшүүлсэн олон төрлийн интеллектүүдийн нэгдэлийг ч багтааж болно. Үүний зэрэгцээ, шинээр төрөн гарч ирсэн Емил Жак Далкросзын хөгжмийн хүмүүжил, Александрын техник зэрэг сургалтууд нь багш нарын багшлах арга барилд шинээр нэвтэрч олон тооны сайн дурын багууд ажиллаж эхэлж байна. Германы хөгжмийн их сургуулиудын дэргэд Александрын техникийг аргачлал болгон байнга ашиглах салбарууд 20 зууны сүүл үеэс ажиллаж эхэлсэн ба энэ нь хөгжмөөр дамжуулан биеийн хөдөлгөөний эвсэлийг ухаан санааны төвлөрөлтэй хамтруулан хөгжүүлэх аргууд юм. Хүний хийх хөдөлгөөнөөс шалтгаалан тоглож байгаа хөгжмийн зэмсэгээ хэрхэн эзэмших чадвар нь сайжирна хэмээн үздэг. Мэргэжлийн хөгжмийн сургуулиудад элсэлтийн шалгалтын явцад хөдөлгөөний эвсэлийн тал дээр голчлон анхаардаг нь ч үүнтэй холбоотой юм. Германы хөгжмийн багш Линда Гросман Улаанбаатар хотноо ажиллаж байхдаа хөгжмийн зэмсэг хувь хүний биеийн хөдөлгөөн хоёр нэгдэн оюун ухаанаараа тоглох нь хөгжимдөх урлагийн гол амин сүнс нь юм гэж хэлж байсан юм. Энэ нь хөдөлгөөний төв нь хөгжимдөх урлагийн гол төв нь юм хэмээн үздэг Александрын техникийн гол үзэлтэй утга нэг юм.

Сүүлийн жилүүдэд гадаадын орнуудад бас нэгэн шинэ сургалтын хэлбэр түгэн дэлгэрч байгаа нь тоглоомоор дамжуулан сургах үйл явц юм. Энэ хэлбэр нь европын орнуудад түгэн дэлгэрээд удаагүй байгаа ч хүүхдийн ой тогтооц, сэтгэн бодох чадвар, дүрслэл мөн дуулах ур чадварыг хөгжүүлэхэд олон төрлийн тоглоомийг ашиглаж ирсэн туршлага манай оронд эрт дээр үеэс улмжлагдан ирсэн билээ. Хүүхдүүд тоглодог, томчууд ч тоглодог олон төрлийн тоглоомууд байна. Тоглоом тоглосноор, ямар нэгэн зүйлийн агуулгыг ойлгох, түүгээр дамжуулан сэтгэлийн хөдлөл, хамтран ажиллах чадвар суулгах, мөн ухааныг цогцоор хөгжүүлэх, тойрон байгаа орчноо таних, шийдвэр гаргах, дүрэм баримтлах гэсэн олон төрлийн чадамжуудад сургадаг хэмээн үзэж байна. Хөгжим, дуу, хэмнэл нь тоглох үед чухал үүрэгтэй оролцдог. Хөгжимлөг, хэмнэлтэй тоглоомуудын тоонд түргэн хэллэг, тааврууд болон олон төрлийн наадгай, шагай зэрэгийг хослуулан ашиглаж хамтач хүмүүжилд болон дүрэм баримтлах сахилга бат зэрэгт сургаж болох юм. Европын орнуудад хөгжиж байгаа хөгжмөөр дамжуулан тоглох тоглоомууд нь дүрд хувирах, хөгжим сонсоод амьдрал дахь нөхцөл байдал, мэргэжил, зан үйлийг тодорхойлох, таах, түргэн хугацаанд шийдвэр гаргах зэрэг зорилгуудыг агуулж байгаа нь ч мөн манай орны эртнээс уламжлагдан ирсэн тоглоомыг ашиглан үр хүүхдээ хүмүүжүүлэх зорилготой нийцэж байгаа юм. Дэлхийн бүхий л орнуудын үндэсний соёлд төрөл бүрийн тоглоомууд олон жилийн өмнөөс уламжлан

ирсэн байдаг. Эдгээрээс, багш хүн өөрийн судалгаанд тулгуурлан сонгон авч хөгжмийн хичээлээр дамжуулан дэлхийн соёлтой сурагчдаа танилцуулах боломжууд эндээс харагдана. Тоглох явцад ямар нэгэн мэдлэг, чадвар, мэдээлэл бүр нь маш түргэн ойлгогддог гэдгийг ч сурган хүмүүжүүлэх ухааны эрдэмтэд нотолж байгаа юм. Өөр үгээр хэлбэл тоглоомоор дамжуулан сургах нь ашиг тустай, яагаад гэвэл урлаг бол бас нэгэн төрлийн тоглоом юм-үзэл санаа, өнгө будаг, дүр дүрслэл, бодол санаа, сэтгэлийн хөдөлгөөн ба биеийн хөдөлгөөн гэх мэт.

Өнөөдөр техникийн дэвшил, хөгжил дээр тулгуурлан хөгжим сонсох нь бидний өдөр тутмын “хэрэгцээ” болтлоо хөгжжээ. Энэ нь мэргэжлийн хөгжмийн багш нар болон ерөнхий боловсролын сургуулиудад хөгжмийн хичээлийг заадаг багш нарын хувьд уран сайхны болон хөгжмийн чанарын тал дээр анхааралаа хандуулах бас нэгэн дохио болж байгаа юм. Хүний амьдралд хөгжмийн гүйцэтгэх үүрэг нь хүмүүн бидний урлагийн мэдрэмжтэй салшгүй холбоотой бөгөөд ямар хөгжим сонсвол аль насанд зохистой, хөгжим бидний амьдралын тухайн цаг үе, насанд тохирсон байдаг талаар хичээлийн агуулгад тусгайлан заах нь чухал мэт санагдана. Хэт хүнд, эсвэл суртал ухуулга хийсэн үг, хэмнэлтэй хөгжим олноор байдгаас бага насны хүүхэд багачуудыг хамгаалж явах нь багш хүний үүрэг болох ёстой юм. Мэдээллийн эрин зууны энэ үед технологи бидний амьдралд хэрэгцээтэй зүйлүүдийг ихээр өгөхийн зэргэцээ шийдэхэд бэрх асуудлуудыг ч үүсгэж байна. Энэ нь хэт их мэдээлэл, реклам сурлатчилгаа, тохилог хэрэглээ нь бодол санааны болон биеийн залхуурал төрүүлэх, сахилга бат, биеэ авч явах тал дээр санаачлага багатай болгох зэргээр илэрч байгаа нь ажиглагддаг. Энэ нь гэгээрэл, ёс суртахууны өндөр хэм хэмжээнд хүргэх зорилго агуулж буй сургуулийн орчинд зарим талаар саад болох хандлагуудыг авчирч байна. Үүний нэг жишээ нь хэт их олширч байгаа төрөл бүрийн шоу, акцън буюу хөдөлгөөн ихтэй ч утга багатай кино зэрэг нь бараг бидний амьдралын зайлшгүй хэрэгцээ болж байгаа явдал юм. Үүнээс залуу үеэ сэргийлэх зорилгоор өндөр хөгжилтэй орнуудын сургуулиуд хүүхдийг эдгээр зүйлүүдээс хол байлгах шаардлагуудыг ч тавьдаг болжээ. Энэ нь мөн л чанаргүй хөгжмөөс хүүхдийг хол байлгах гэсэн санааг агуулж байгаа ба хөгжим ба боловсролын холбоог ойлгон гаргаж байгаа чиг хандлагууд юм. Иймд хүүхдийг болон залуу үеийг хөгжмөөр дамжуулан сургах бодлого төлөвлөлтөнд юун түрүүн сэтгэлийн зөв хөдлөлийг төрүүлэх хөгжмийг сонгон авах нь чухал юм. Тарьж буй үрээ хэрхэн арчлах нь цэцэгчин хүнээс шалтгаалдагтай адил сурган хүмүүжүүлэгч нар ч мөн арга барилаа сонгон ажиллах нь ирээдүйн хүнийг хүмүүжүүлэхэд хамгийн гол үүрэгтэй юм.

НОМ ЗҮЙ

1. Чулуунцэцэг. О нар (2007), “Бодит юмсыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй зөвлөмж”, УБ.,
2. Aleilo, R. (1999), Strategies for memorizing music: Pedagogical implications, New York
3. Rood, E. (1998) Music Therapy: Improvisation, Communication and Culture. Gilsum, NY
4. Лосев.А.Ф. (2009) Музыка как предмет логики 125-р тал
5. Гун Нили (2015) Музыкальная эстетика 262-р тал

SUMMARY

New trends and strategies of music education in the XXI Century: In this paper, the new trends and strategies of music education in Mongolia and abroad are monitored. The aim is to introduce current and future music educators the new possible ways of teaching music. To help teachers how to enrich their lessons not only through musical activities but also through other interesting for students methods.